

## *Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн гэмтлийн шалтгаан*

### **Чийг ба температур**

#### **Байнгын бага чийг:**

- Мод, цаас, зотон даавуу ба савхи хатаж хуурайшин, хэврэг болно.

#### **Байнгын өндөр чийг:**

- Хөгц үүснэ, металл зэвэрнэ
- Цаас, мод ба савхийг зөөлрүүлнэ

#### **Эрс хурдан өөрчлөлт:**

- Чийг татдаг материалд өөрчлөлт орж, будаг хөндийрч, хагаралт үүсч, мод гажиж, хужир ургалт идэвхжинэ.

#### **Температур:**

- Өндөр температур: Материал дахь химийн урвал идэвхжсэнээр зөөлөн болох буюу хэлбэрээ алдана.
- Бага температур: Материал хатуурч, хугарамтгай болно

### **Гэрэл**

- Хэт хурц гэрэл ба хэт ягаан туяа нь материалд фото химийн өөрчлөлт оруулна.
- Өнгөгүй болох, гандах, хугарах зэрэг фото хими өөрчлөлтүүд явагдана

### **Биологийн хүчин зүйлс**

#### **Бичил амь судлал буюу микробиологи:**

- Ялангуяа өндөр температур ба харьцангуй чийгшилд мөөгөнцөр ба бактер үржинэ.
- Хэт тоосжилт, бохирдолтийн үед үржинэ.

#### **Макробиологи:**

- Шавьж хорхой
- Мэрэгчид

#### **Агаарын бохирдол ба орчны нөлөөгөөр элэгдэх**

- Үйлдвэрлэлийн хүхэрийн давхар исэл, устөрөгчийн хүчил, озон нь материалд түргэн өөрчлөлт орох нөхцөл болно.
- Агаарын бохирдол, тоосжилтын хэсгүүд нь эд өлгийн зүйлийн гадаргууд зураас гаргах, хонхойлгох, өнгөгүй болгох ээргээр гэмтээгч хийн атомыг тээгч болдог.

### **Физик хүчин зүйлс**

#### **Буруу харьцах :**

- Аюулгүй байдлыг хангаагүй баглаа боодол, муу хайрцаг сав
- Тээвэрлэлтийн үед буруу харьцах
- Цаг агаарын муу нөхцөлд тээвэрлэх

### **Тохиромжгүй, муу сан хөмрөг:**

- Хортон шавьж, модны хүр хорхой, цох хорхой, цагаан эрвээхэй, оготно
- Хэт тоосжилт, бохирдолт
- Үзмэр, эд өлгийн зүйлийг хэт олноор байрлуулах, буруу өрөх, гар хүрэхгүй газар тавих
- Сан хөмрөгийн орчны муу нөхцөл
- Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зөв сайн авахгүй байх, галын дохиоллын систем шаардлага хангахгүй байх

### **Шаардлага хангахгүй туслах материал ба тоног төхөөрөмж:**

- Стандартын бус туслах материал, шаардлага хангахгүй буюу иж бус тоног төхөөрөмж
- Буруу харьцах ба зориулалтын бус сан хөмрөгийн өрөө ба үзүүллэгийн танхимд хадгалах

### **Ашигласан ном**

Feller, R, Control of Deteriorating Effects of Light upon Museum Objects, Museum, Paris, Unesco, 17, no.2 (1964), pp.57-98.

Plenderleith, H and Werner, A, The Conservation of Antiquities and Works of Art, 2nd ed., London, Oxford university Press, 1976.

Stolow, N, Conservation Standards for Works of Art in Transit and on Exhibition, Paris Unesco, 1979.

Thompson, G, The Museum Environment, 2nd ed., Butterworths, 1986.

Бичсэн Сара МсХуг, Орчуулсан: **Д.Бумаа Ph.D**  
МҮМ-н Музей судлалын мэргэжил арга зүйн төвийн дарга